



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар A/654

Арвайхээр

**Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа
явуулах тухай**

Монгол улсын “Газрын тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаагаар эзэмшүүлэх нэг нэгж талбарын газрын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулах бөгөөд дуудлага худалдааг 2019 оны 11 дүгээр сарын 25-нд зохион байгуулна.

3. Дуудлага худалдаа явуулах тухай зар мэдээг 2019 оны 10 дугаар сарын 24-ны өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж холбогдох журмын дагуу оролцогчдын материалыг хүлээн авч товлосон хугацаанд дуудлага худалдааг зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч. Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101227

Аймгийн Засаг даргын 2019 оны 10
дугаар сарын 24-ны өдрийн 41654 дугаар
захирамжийн хавсралт

АРВАЙХЭЭР СУМАНД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ГАЗРЫН БАЙРШИЛ,
ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, АНХНЫ ҮНЭ, ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Эзэмшүүлэх газрын байршил	Газар эзэмшүүлэх зориулалт	Эзэмшүүлэх газрын хэмжээ /м ² /	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ /мян.төг/	Дэнчингийн хэмжээ /мян.төг/
1.	13 дугаар баг Дөл хороолол	Үйлчилгээ	839	3020.4	302.04